



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/᠑᠑

Булган сум

Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн сумдад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймагт 2023-2024 оны мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндэрч малчин өрхүүдийн цасанд боогдсон зам даваа нээх, өвс тэжээл хүргэх болон төрийн үйлчилгээг зохион байгуулахад Баяннуур, Баян-Агт, Бүрэгхангай, Дашинчилэн, Гурванбулаг, Орхон, Сайхан, Рашаант сумдад тус бүр 5,000,000 (таван сая) төгрөг, нийт 40,000,000 (дөчин сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх санхүүжилтийг Байгаль хамгаалах сангийн "Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал"-аас санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

